1.2 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг

Нийт 841 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс гэмт хэрэг 215 буюу 34.3 хувиар өсч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 7.5 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 584, сард 49, хоногт 2 хэрэг үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /сүүлийн 10 жилээр/



1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/




1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал

Нийт бүртгэгдсэн хэргийн 661 буюу 78.6 хувь нь хөнгөн, 180 буюу 21.4 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 34.1 хувиар, хүнд гэмт хэрэг 35.3 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.



1.5. Орон нутгийн гэмт хэрэгт эзлэх хувийн жин, сараар, 2019 он




1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Аймгийн хэрэгт эзлэх хувь
		2018 он	2019 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	7	9	28.6	1.1
	Үүнээс: Хүнийг алах	2	4	2.0 дах	0.5
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	170	179	5.3	21.3
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	8	11	37.5	1.3
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	19	14	-26.3	1.7
	Үүнээс: Хүчиндэх	17	12	-29.4	1.4
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	1	1	0.0	0.1
5	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг		1		0.1
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	364	567	55.8	67.4
6	Хулгайлах	171	184	7.6	21.9
	Залилах	29	49	69.0	5.8
	Дээрэмдэх	6	5	-16.7	0.6
	Мал хулгайлах	120	287	2.4 дах	34.1
7	Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг		2		0.2
8	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1			0.0
9	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	2	1	-50.0	0.1
10	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	3	2	-33.3	0.2
11	Авлигын эсрэг гэмт хэрэг	10	20	2.0 дах	2.4
12	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	4	6	50.0	0.7
13	Хүрээлэн байгаа орчны эсрэг	10	13	30.0	1.6
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	35	26	-25.7	3.1
14	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	35	26	-25.7	3.1

1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад даваа гарагт үйлдэгдсэн гэмт хэрэг 20 буюу 19.2, бямба гарагт 24 буюу 26.1, пүрэв гарагт 23 буюу 27.7, баасан гарагт 33 буюу 32.4, мягмар гарагт 34 буюу 36.2, лхагва гарагт 36 буюу 43.4, ням гарагт 45 буюу 66.2 хувиар тус тус өссөн байна.


Хэргийг цагаар нь авч үзвэл 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн гэмт хэрэг 24 буюу 20.0, 14-19 цагийн хооронд 8 буюу 4.8, 19-22 цагийн хооронд 37 буюу 34.9, 22-06 цагийн хооронд 146 буюу 62.4 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.





1.8 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар

Гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 5 буюу 9.4, олон нийтийн газарт 5 буюу 17.9, гэр, орон сууцанд 60 буюу 30.8, төрийн байгууллагад 7 буюу 38.9, бусад газарт 139 буюу 51.1 хувиар, төрийн бус байгууллагад 4 буюу 3.0 дахин тус тус өсч, авто зам дээр үйлдэгдсэн гэмт хэрэг 5 буюу 16.1 хувиар буурч, аж ахуйн нэгжид үйлдэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеийн түвшинд байна.



1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал

Нийт бүртгэгдсэн хэргийн 155 буюу 18.4 хувь нь согтуугаар, 35 буюу 4.2 хувь нь хүүхэд оролцож, 54 буюу 6.4 хувь нь эмэгтэй хүн оролцож, 29 буюу 3.4 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэж, 87 буюу 10.3 хувь нь бүлэглэн, 1 буюу 0.1 хувь нь галт зэвсгээр тус тус үйлдэгдсэн байна.

Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь

Хэнтий аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 556 буюу 66.1 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 55.8 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 8.3 нэгжээр өссөн.

Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 2.9 нэгжээр бага байна.



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг


Хэрэг бүртгэлтийн 761 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 225 хэрэг буюу 42.0 хувиар, үүнээс 425 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 170 буюу 66.7 хувиар тус тус өссөн байна.

Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 622 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 209 буюу 50.6 хувиар өссөн. Холбогдогчдын 576 буюу 92.6 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 50.8 хувиар, 46 буюу 7.4 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 48.4 хувиар, 46 буюу 7.4 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 70.4 хувиар тус тус өссөн байна.

3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал






Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

4.1 Хохирсон хүн, хуулийн этгээд

Гэмт хэргийн улмаас 822 хүн, 2 хуулийн этгээд хохирч, үүнээс 19 хүн нас барж, 183 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 221 буюу 36.8 хувиар өсч, нас барсан хүн 2 буюу 9.5, гэмтсэн хүн 15 буюу 7.6 хувиар тус тус буурсан байна.



4.2. Учирсан хохирол




Хүн, хуулийн этгээдэд учирсан 2426.4 сая төгрөгийн хохирлын 42.0 хувийг нөхөн төлүүлж, 25.8 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеийнхээс хохирлын хэмжээ 748.2 буюу 44.6 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 525.4 буюу 2.1 дахин, битүүмжилсэн хөрөнгө 20.8 буюу 5.2 дахин тус тус өссөн байна.

Тав. Зөрчил

Хэнтий аймаг дахь цагдаагийн газрын хэмжээнд нийт 30.763 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 11.380 буюу 58.7 хувиар, 30570 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 11.338 буюу 59.0 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 29.930 буюу 97.3 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 81 буюу 0.3 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 169 буюу 0.5 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 583 буюу 1.9 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 29.427 хүн, 7 хуулийн этгээдийг 1234.3 сая төгрөгөөр торгох, 487 хүнийг баривчлах, 649 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс торгосон шийтгэл 11.406 буюу 63.3 хувиар өсч, баривчилсан шийтгэл 67 буюу 12.1, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 5 буюу 0.8 хувиар тус тус буурсан байна.

2019 онд Хэнтий аймагт нийт 1493 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 771 буюу 34.1 хувиар буурсан байна.

---oooOooo---



ДӨРӨВ. ЗАРИМ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

4.1 ХҮНИЙГ АЛАХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн хэрэг

1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг

Эрүүгийн хуулийн 10 дугаар бүлгийн 10.1 дүгээр зүйл “Хүнийг алах” гэмт хэрэг улсын хэмжээнд 2019 онд нийт 197 бүртгэгдсэн нь өмнөх оноос 5 хэргээр буюу 2.6 хувиар, орон нутгийн хэмжээнд 87 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 5 хэргээр буюу 6.1 хувиар тус тус өсч, нийслэлийн хэмжээнд 110 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийн түвшинд байна.

1.2 Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт нутаг дэвсгэрээр



	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь		Өсөлт, бууралтын нэгж
	2018 он	2019 он		2018 он	2019 он	
Улсын хэмжээнд	192	197	2.6	0.5	0.6	0.1
Нийслэлд	110	110	0.0	0.4	0.5	0.1
Орон нутагт	82	87	6.1	0.8	0.8	0.0

1.3 Гэмт хэргийн түвшин /2010–2019 он/




Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 209, сард 17 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.



1.4 Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг


Өмнөх оны мөн үетэй харьцуулахад пүрэв гарагт үйлдэгдсэн хэрэг 2 буюу 8.0, даваа гарагт 2 буюу 6.5, баасан гарагт 4 буюу 16.0, лхагва гарагт 8 буюу 30.8, мягмар гарагт 8 буюу 32.0 хувиар тус тус өсч, ням гарагт үйлдэгдсэн хэрэг 7 буюу 25.0, бямба гарагт 12 буюу 37.5 хувиар тус тус буурчээ.

Хэргийг цагаар нь авч үзвэл 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 14 буюу 45.2, 22-06 цагийн хооронд 2 буюу 2.5 хувиар тус тус өсч, 19-22 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 11 буюу 26.2 хувиар буурч, 14-19 цагийн хооронд бүртгэгдсэн хэрэг өмнөх оны мөн үеийн түвшинд байна.



1.5 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад гудамж талбайд үйлдэгдсэн хэрэг 2 буюу 6.3, гэр орон сууцанд 12 буюу 11.0 хувиар тус тус өсч, бусад газарт үйлдэгдсэн хэрэг 2 буюу 6.1, олон нийтийн газарт 5 буюу 50.0, аж ахуйн нэгж, байгууллагад 3 буюу 50.0 хувиар тус тус буурч, төрийн байгууллагад болон төрийн бус байгууллагад үйлдэгдсэн хэргүүд өмнөх оны мөн үеийн түвшинд, авто замд үйлдэгдсэн хэрэг 1 бүртгэгдсэн байна.



1.6 Гэмт хэрэг үйлдсэн байдал

Нийт бүртгэгдсэн хэргийн 122 буюу 61.9 хувь нь согтуугаар, 4 буюу 2.0 хувь нь хүүхэд оролцож, 16 буюу 8.1 хувь нь эмэгтэй хүн оролцож, 12 буюу 6.1 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 13 буюу 6.6 хувь нь бүлэглэн, 1 буюу 0.5 хувь нь гадаадын иргэн тус тус үйлдсэн байна.

Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

2.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 216 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15 буюу 7.4 хувиар өссөн. Холбогдогчдын 16 буюу 7.4 хувь нь эмэгтэй, 200 буюу 92.6 хувь нь эрэгтэй, 8 буюу 3.7 хувь нь насанд хүрээгүй хүн байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс эрэгтэй хүн 21 буюу 11.7 хувиар, хүүхэд 8.0 дахин тус тус өсч, эмэгтэй хүн 6 буюу 27.3 хувиар буурсан байна.

2.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал






Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол

3.1 Хохирсон хүн, учирсан хохирол

Гэмт хэргийн улмаас 205 хүн хохирч, үүнээс 192 хүн нас барсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хохирсон хүн 9 буюу 4.6 хувиар, нас барсан хүн 24 буюу 14.3 хувиар тус тус өссөн байна. Нас барсан хүний 41 буюу 21.4 хувь нь эмэгтэй, 2 буюу 1.0 хувь нь хүүхэд байна.

Хэргийн улмаас хүнд учирсан 1028.2 сая төгрөгийн хохирлын 78.7 хувийг нөхөн төлүүлж, 175.7 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.



---0000000---




4.2 ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн хэрэг

1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг


Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлэг “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг” гэмт хэрэг улсын хэмжээнд 2019 онд нийт 8265 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 869 хэргээр буюу 9.5 хувиар, нийслэлийн хэмжээнд 5183 бүртгэгдсэн нь 684 хэргээр буюу 11.7 хувиар, орон нутгийн хэмжээнд 3073 бүртгэгдсэн нь 187 хэргээр буюу 5.7 хувиар тус тус буурсан байна.

1.2 Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт нутаг дэвсгэрээр



	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь		Өсөлт, бууралтын нэгж
	2018	2019		2018	2019	
Улсын хэмжээнд	9134	8265	-9.5	25.2	26.2	1.0
Нийслэлд	5867	5183	-11.7	22.9	25.6	2.7
Орон нутагт	3254	3073	-5.6	31.0	27.4	-3.6
Бусад	13	9	-30.8	20.3	15.3	-5.1

1.3 Гэмт хэргийн түвшин /2010-2019 он/



Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 7642, сард 637, хоногт 21 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.




1.4 Гэмт хэргийн зүйл анги

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Тухайн гэмт хэргт эзлэх хувь
		2018 он	2019 он		
1	11.1 Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах	295	238	-19.3	2.9
2	11.2 Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах	1	2	2.0 дах	0.0
3	11.3 Хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах	31	34	9.7	0.4
4	11.4 Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах	401	319	-20.4	3.9
5	11.5 Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол болгоомжгүйгээр учруулах	68	74	8.8	0.9
6	11.6 Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах	8128	7391	-9.1	89.4
7	11.7 Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	210	207	-1.4	2.5

1.5 Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг


Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ням гарагт үйлдэгдсэн хэрэг 48 буюу 3.8, лхагва гарагт 56 буюу 4.6, мягмар гарагт 98 буюу 7.7, баасан гарагт 101 буюу 7.7, пүрэв гарагт 156 буюу 11.8, бямба гарагт 166 буюу 12.3, даваа гарагт 244 буюу 17.2 хувиар тус тус буурчээ.

Хэргийг цагаар нь авч үзвэл 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 88 буюу 6.6, 14-19 цагийн хооронд 392 буюу 18.1, 19-22 цагийн хооронд 152 буюу 8.0, 22-06 цагийн хооронд 237 буюу 6.3 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.



1.6 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад бусад газарт үйлдэгдсэн хэрэг 17 буюу 1.9, төрийн бус байгууллагад 2 буюу 4.8 хувиар тус тус өсч, аж ахуйн нэгж, байгууллагад үйлдэгдсэн хэрэг 18 буюу 5.5, гэр орон сууцанд 234 буюу 6.6, гудамж талбайд 327 буюу 12.4, олон нийтийн газарт 247 буюу 15.9, нийтийн тээвэрт 7 буюу 31.8, төрийн байгууллагад 39 буюу 34.2, авто замд үйлдэгдсэн хэрэг 16 буюу 55.1 хувиар тус тус буурсан байна.



1.7 Гэмт хэрэг үйлдсэн байдал

Нийт бүртгэгдсэн хэргийн 3256 буюу 39.4 хувь нь согтуугаар, 232 буюу 2.8 хувь нь хүүхэд оролцож, 878 буюу 10.6 хувь нь эмэгтэй хүн оролцож, 913 буюу 11.0 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 219 буюу 2.6 хувь бүлэглэн үйлдсэн байна.




Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

2.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 6672 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 264 буюу 3.8 хувиар буурсан. Холбогдогчдын 5909 буюу 88.6 хувь нь эрэгтэй, 763 буюу 11.4 хувь нь эмэгтэй, 247 буюу 3.7 хувь нь насанд хүрээгүй хүн байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс эрэгтэй хүн 4.3 хувиар буурч, эмэгтэй хүн 0.3 хувиар, насанд хүрээгүй хүн 20.5 хувиар тус тус өссөн байна.

2.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал




Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол

3.1 Хохирсон хүн, учирсан хохирол

Гэмт хэргийн улмаас 8542 хүн хохирч үүнээс 7416 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хохирсон хүн 606 буюу 6.6 хувиар, гэмтсэн хүн 541 буюу 6.8 хувиар тус тус буурсан. Гэмтсэн хүний 6684 буюу 90.1 хувь нь хөнгөн, 448 буюу 6.0 хувь нь хүндэвтэр, 284 буюу 3.9 хувь нь хүнд зэргийн гэмтэл авсан.

Хэргийн улмаас хүнд учирсан 7227.9 сая төгрөгийн хохирлын 79.2 хувийг нөхөн төлүүлж, 1008.9 сая төгрөгийн хөрөнгө биүүмжилсэн нь өмнөх оны мөн үеийнхээс нийт хохирол 376.5 буюу 5.0 хувиар буурсан байна.



---oooOooo---




4.3 ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн хэрэг

1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг


Эрүүгийн хуулийн 12 дугаар бүлгийн 12.1 дүгээр зүйл “Хүчиндэх” гэмт хэрэг улсын хэмжээнд 2019 онд 481 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 38 хэргээр буюу 7.3 хувиар, нийслэлийн хэмжээнд 214 бүртгэгдсэн нь 55 хэргээр буюу 20.4 хувиар тус тус буурч, орон нутгийн хэмжээнд 267 бүртгэгдсэн нь 18 хэргээр буюу 7.2 хувиар өссөн байна.

1.2 Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт нутаг дэвсгэрээр



	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь		Өсөлт, бууралтын нэгж
	2018 он	2019 он		2018 он	2019 он	
Улсын хэмжээнд	519	481	-7.3	1.4	1.5	0.1
Нийслэлд	269	214	-20.4	1.0	1.1	0.0
Орон нутагт	249	267	7.2	2.4	2.4	0.0
Бусад	1			0.2		

1.3 Гэмт хэргийн түвшин /2010–2019 он/




Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 360, сард 30, хоногт 1 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.



1.4 Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг


Өмнөх оны мөн үетэй харьцуулахад лхагва гарагт үйлдэгдсэн гэмт хэрэг 1 буюу 1.2, даваа гарагт 16 буюу 22.5 хувиар тус тус өсч, мягмар гарагт үйлдэгдсэн хэрэг 15 буюу 20.8, бямба гарагт 14 буюу 16.9, баасан гарагт 10 буюу 11.8, ням гарагт 8 буюу 13.6, пүрэв гарагт 8 буюу 11.9 хувиар тус тус буурчээ.

Хэргийг цагаар нь авч үзвэл 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 5 буюу 4.9, 14-19 цагийн хооронд 17 буюу 18.5 хувиар тус тус өсч, 19-22 цагийн хооронд 16 буюу 22.2, 22-06 цагийн хооронд 44 буюу 17.4 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.



1.5 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад гэр орон сууцанд үйлдэгдсэн хэрэг 8 буюу 2.7 хувиар өсч, олон нийтийн газарт 29 буюу 59.2, бусад газар 5 буюу 5.6 хувиар, аж ахуйн нэгж, байгууллагад 4 буюу 40.0 хувиар, төрийн бус байгууллагад 1 буюу 50.0 хувиар тус тус буурч, гудамж талбайд үйлдэгдсэн хэрэг өмнөх оны мөн үеийн түвшинд байна.



1.6 Гэмт хэрэг үйлдсэн байдал


Нийт бүртгэгдсэн хэргийн 112 буюу 23.3 хувь нь согтуугаар, 16 буюу 3.3 хувь нь хүүхэд оролцож, 5 буюу 1.0 хувь нь эмэгтэй хүн оролцож, 50 буюу 10.4 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 22 буюу 4.6 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.

Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

2.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 314 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24 буюу 7.1 хувиар буурсан. Холбогдогчдын 311 буюу 99.0 хувь нь эрэгтэй, 3 буюу 1.0 хувь нь эмэгтэй, 17 буюу 5.4 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс эмэгтэй өмнөх оны мөн үеийн түвшинд, эрэгтэй хүн 24 буюу 7.2 хувиар, хүүхэд 7 буюу 29.2 хувиар тус тус буурсан байна.

2.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал






Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол

3.1 Хохирсон хүн, учирсан хохирол

Гэмт хэргийн улмаас 492 хүн хохирч үүнээс 84 хүн гэмтэж, 3 хүн нас барсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хохирсон хүн 5 буюу 1.0 хувиар, нас барсан хүн 1 буюу 50.0 хувиар өсч, гэмтсэн хүн 5 буюу 5.6 хувиар буурсан байна.

Хэргийн улмаас хүнд учирсан 562.1 сая төгрөгийн хохирлын 369.6 сая төгрөг буюу 9.8 хувийг нөхөн төлүүлж, 54.8 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеийнхээс учирсан хохирол 79.5 сая төгрөг буюу 16.5 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 50.5 сая төгрөг буюу 15.8 хувиар тус тус өссөн байна.



---oooOooo---




4.4 ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн хэрэг

1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг


Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлгийн 17.1 дүгээр зүйл “Хулгайлах” гэмт хэрэг улсын хэмжээнд 2019 онд нийт 8968 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 3360 хэргээр буюу 27.3 хувиар, нийслэлийн хэмжээнд 3002 хэргээр буюу 31.5 хувиар, орон нутгийн хэмжээнд 358 хэргээр буюу 12.8 хувиар тус тус буурсан байна.

1.2 Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт нутаг дэвсгэрээр



	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь		Өсөлт, бууралтын нэгж
	2018 он	2019 он		2018 он	2019 он	
Улсын хэмжээнд	12328	8968	-27.3	34.0	28.4	-5.6
Нийслэлд	9539	6537	-31.5	37.2	32.3	-4.9
Орон нутагт	2789	2431	-12.8	26.6	21.7	-4.9

1.3 Гэмт хэргийн түвшин /2010-2019 он/




Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 8448, сард 704, хоногт 23, цагт 1 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

1.4 Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад лхагва гарагт үйлдэгдсэн хэрэг 391 буюу 22.5, ням гарагт 366 буюу 23.3, бямба гарагт 429 буюу 26.5, баасан гарагт 532 буюу 28.8, мягмар гарагт 532 буюу 29.4, даваа гарагт 570 буюу 29.6, пүрэв гарагт 540 буюу 29.8 хувиар тус тус буурсан.




Хэргийг цагаар нь авч үзвэл 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 848 буюу 27.2, 14-19 цагийн хооронд 1144 буюу 30.6, 19-22 цагийн хооронд 406 буюу 25.7, 22-06 цагийн хооронд 962 буюу 24.7 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.



1.5 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад бусад газарт үйлдэгдсэн хэрэг 64 буюу 6.3, аж ахуйн нэгжид 207 буюу 21.1, гэр орон сууцанд 1521 буюу 25.7, олон нийтийн газарт 498 буюу 27.9, нийтийн тээвэрт 72 буюу 32.6, төрийн байгууллагад 25 буюу 35.2, авто замд 4 буюу 40.0, гудамж талбайд 919 буюу 41.4, төрийн бус байгууллагад 50 буюу 48.1 хувиар тус тус буурсан байна.



1.6 Гэмт хэрэг үйлдсэн байдал


Нийт бүртгэгдсэн хэргийн 439 буюу 4.9 хувь нь согтуугаар, 567 буюу 6.3 хувь нь хүүхэд оролцож, 360 буюу 4.0 хувь нь эмэгтэй хүн оролцож, 519 буюу 5.8 хувь нь бүлэглэн, 1 буюу 0.01 хувь нь гадаадын иргэн үйлдэгдсэн байна.

Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

2.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 3450 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 51 буюу 1.5 хувиар буурсан. Холбогдогчдын 3151 буюу 91.3 хувь нь эрэгтэй, 299 буюу 8.7 хувь нь эмэгтэй, 783 буюу 22.7 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 51 эрэгтэй хүн 76 буюу 2.4 хувиар буурч, эмэгтэй хүн 25 буюу 9.1, хүүхэд 280 буюу 55.7 хувиар тус тус өссөн байна.

2.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал






Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол

3.1 Хохирсон хүн, хуулийн этгээд, учирсан хохирол

Гэмт хэргийн улмаас 9004 хүн, 15 хуулийн этгээд хохирсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хохирсон хүн 2558 буюу 22.1 хувиар буурч, хуулийн этгээд 7 буюу 87.5 хувиар өссөн байна.

Хүн, хуулийн этгээдэд учирсан 18690.7 сая төгрөгийн хохирлын 3713.6 сая төгрөг буюу 19.9 хувийг нөхөн төлүүлж, 410.9 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеийнхээс учирсан хохирол 677.6 сая төгрөг буюу 3.5 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 360.6 сая төгрөг буюу 8.9 хувиар тус тус буурсан байна.



---оооОооо---



4.5 ХУВИЙН ӨМЧИЙГ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн хэрэг

1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг


Энэ төрлийн гэмт хэрэг улсын хэмжээнд 2019 онд нийт 7994 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 2371 хэргээр буюу 22.9 хувиар, нийслэлийн хэмжээнд 5797 бүртгэгдсэн нь 2119 хэргээр буюу 26.8 хувиар, орон нутгийн хэмжээнд 2197 бүртгэгдсэн нь 252 хэргээр буюу 10.3 хувиар тус тус буурсан байна.

1.2 Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт нутаг дэвсгэрээр



	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь		Өсөлт, бууралтын нэгж
	2018 он	2019 он		2018 он	2019 он	
Улсын хэмжээнд	10365	7994	-22.9	28.6	25.4	-3.3
Нийслэлд	7916	5797	-26.8	30.9	28.6	-2.2
Орон нутагт	2449	2197	-10.3	23.3	19.6	-3.7

1.3 Гэмт хэргийн түвшин /2010-2019 он/




Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 6564, сард 547, хоногт 18 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.



1.4 Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг


Өмнөх оны мөн үетэй харьцуулахад лхагва гарагт үйлдэгдсэн хэрэг 260 буюу 17.8, ням гарагт 258 буюу 19.2, бямба гарагт 294 буюу 21.6, баасан гарагт 377 буюу 24.1, даваа гарагт 400 буюу 25.1, пүрэв гарагт 384 буюу 25.4, мягмар гарагт 398 буюу 26.0 хувиар тус тус буурчээ.

Хэргийг цагаар нь авч үзвэл 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 548 буюу 21.3, 14-19 цагийн хооронд 781 буюу 25.6, 19-22 цагийн хооронд 271 буюу 20.6, 22-06 цагийн хооронд 771 буюу 22.5 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.



1.5 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад бусад газарт үйлдэгдсэн хэрэг 15 буюу 1.7, аж ахуйн нэгжид 139 буюу 18.2, олон нийтийн газарт 302 буюу 21.5, гэр орон сууцанд 1479 буюу 25.4, гудамж талбайд 333 буюу 26.4, төрийн байгууллагад 17 буюу 30.4, төрийн бус байгууллагад 31 буюу 39.2, нийтийн тээвэрт 50 буюу 50.5, авто замд 5 буюу 62.5 хувиар тус тус буурсан байна.



1.6 Гэмт хэрэг үйлдсэн байдал


Нийт бүртгэгдсэн хэргийн 401 буюу 5.0 хувь нь согтуугаар, 494 буюу 6.2 хувь нь хүүхэд оролцож, 311 буюу 3.9 хувь нь эмэгтэй хүн оролцож, 437 буюу 5.5 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.

Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

2.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 3074 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23 буюу 0.7 хувиар буурсан. Холбогдогчдын 2804 буюу 91.2 хувь нь эрэгтэй, 270 буюу 8.8 хувь нь эмэгтэй, 673 буюу 21.9 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс эрэгтэй хүн 39 буюу 1.4 хувиар буурч, эмэгтэй хүн 16 буюу 6.3, хүүхэд 227 буюу 50.9 хувиар тус тус өссөн байна.

2.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал






Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол

3.1 Хохирсон хүн, хуулийн этгээд, учирсан хохирол

Гэмт хэргийн улмаас 8023 хүн, 7 хуулийн этгээд хохирсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хохирсон хүн 1768 буюу 18.1 хувиар буурч, хуулийн этгээд 3 буюу 75.0 хувиар өссөн байна.

Хүн, хуулийн этгээдэд учирсан 15843.8 сая төгрөгийн хохирлын 3067.5 сая төгрөг буюу 19.4 хувийг нөхөн төлүүлж, 390.6 сая төгрөгийн хөрөнгө биүүмжилсэн нь өмнөх оны мөн үеийнхээс учирсан хохирол 684.6 сая төгрөг буюу 4.1 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 567.6 сая төгрөг буюу 15.6 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 63.3 сая төгрөг буюу 13.9 хувиар тус тус буурсан байна.



---oooOooo---



4.6 ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн хэрэг


1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг

Энэ төрлийн гэмт хэрэг улсын хэмжээнд 2019 онд нийт 267 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 164 хэргээр буюу 38.1, нийслэлийн хэмжээнд 126 бүртгэгдэж 66 хэргээр буюу 34.4, орон нутгийн хэмжээнд 141 бүртгэгдэж 98 хэргээр буюу 41.0 хувиар тус тус буурсан байна.

1.2 Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт нутаг дэвсгэрээр

Д/д	Нэгж	2018 он	2019 он	Өсөлт, бууралт		Д/д	Нэгж	2018 он	2019 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь					Тоо	Хувь
1	Архангай	17	7	-10	-58.8	17	Төв	19	7	-12	-63.2
2	Баян-Өлгий	2	3	1	50.0	18	Увс	7	6	-1	-14.3
3	Баянхонгор	32	9	-23	-71.9	19	Ховд	3	3	0	0.0
4	Булган	4	8	4	2.0 дах	20	Хөвсгөл	40	27	-13	-32.5
5	Говь-Алтай	6	3	-3	-50.0	21	Хэнтий	14	5	-9	-64.3
6	Говьсүмбэр	8				Нийслэлд					
7	Дархан-Уул	1	2	1	2.0 дах	22	Баянгол	68	24	-44	-64.7
8	Дорноговь	6	4	-2	-33.3	23	Баянзүрх	55	45	-10	-18.2
9	Дорнод	5	3	-2	-40.0	24	Сүхбаатар	19	9	-10	-52.6
10	Дундговь	6	7	1	16.7	25	Сонгинохайрхан	31	31	0	0.0
11	Завхан	1	1	0	0.0	26	Хан-Уул	9	6	-3	-33.3
12	Орхон	4	5	1	25.0	27	Чингэлтэй	7	7	0	0.0
13	Өвөрхангай	48	21	-27	-56.3	28	Багануур	2	2	0	0.0
14	Өмнөговь	4	3	-1	-25.0	29	Багахангай				
15	Сүхбаатар	4	7	3	75.0	30	Налайх	1	2	1	2.0 дах
16	Сэлэнгэ	8	10	2	25.0	31	Бусад				

1.3 Гэмт хэргийн түвшин /2010-2019 он/




Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 267, сард 22 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

1.4 Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг


Өмнөх оны мөн үетэй харьцуулахад баасан гарагт үйлдэгдсэн хэрэг 12 буюу 21.8, пүрэв гарагт 15 буюу 25.0, ням гарагт 18 буюу 34.6, мягмар гарагт 23 буюу 36.5, даваа гарагт 37 буюу 45.1, бямба гарагт 28 буюу 47.5, лхагва гарагт 31 буюу 51.7 хувиар тус тус буурчээ.

Хэргийг цагаар нь авч үзвэл 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 23 буюу 31.5, 14-19 цагийн хооронд 40 буюу 48.8, 19-22 цагийн хооронд 18 буюу 38.3, 22-06 цагийн хооронд 83 буюу 36.2 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.



1.5 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад олон нийтийн газарт үйлдэгдсэн хэрэг 7 буюу 2.2 дахин өсч, аж ахуйн нэгжид 2 буюу 18.2, гэр орон сууцанд 24 буюу 35.8, гудамж талбайд 97 буюу 38.2, бусад газарт 48 буюу 52.2 хувиар тус тус буурч, авто замд 1 хэрэг үйлдэгдсэн байна.



1.6 Гэмт хэрэг үйлдсэн байдал


Нийт бүртгэгдсэн хэргийн 22 буюу 8.2 хувь нь согтуугаар, 48 буюу 18.0 хувь нь хүүхэд оролцож, 2 буюу 0.7 хувь нь эмэгтэй хүн оролцож, 32 буюу 12.0 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.

Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

2.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 173 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25 буюу 12.6 хувиар буурсан. Холбогдогчдын 172 буюу 99.4 хувь нь эрэгтэй, 1 буюу 0.6 хувь нь эмэгтэй, 68 буюу 39.3 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс эрэгтэй хүн 24 буюу 12.2, эмэгтэй хүн 1 буюу 50.0 хувиар тус тус буурч, хүүхэд 31 буюу 83.8 хувиар өссөн байна.

2.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал




Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол

3.1 Хохирсон хүн, учирсан хохирол

Гэмт хэргийн улмаас 280 хүн хохирсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 130 буюу 31.7 хувиар буурсан байна.

Хэргийн улмаас хүнд учирсан 1242.5 сая төгрөгийн хохирлын 435.2 сая буюу 35.0 хувийг нөхөн төлүүлж, 8.3 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеийнхээс хохирлын хэмжээ 327.1 сая төгрөг буюу 35.7 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 197.8 сая төгрөг буюу 83.3 хувиар тус тус өсч, битүүмжилсэн хөрөнгө 7.1 сая төгрөг буюу 46.1 хувиар буурсан байна.





4.7 ХАЛААСНЫ ХУЛГАЙН ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн хэрэг


1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.

Энэ төрлийн гэмт хэрэг улсын хэмжээнд 2019 онд нийт 500 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 780 хэргээр буюу 60.9 хувиар, нийслэлийн хэмжээнд 487 бүртгэгдсэн нь 784 хэргээр буюу 61.7 хувиар тус тус буурч, орон нутгийн хэмжээнд 13 бүртгэгдсэн нь 4 хэргээр буюу 44.4 хувиар өссөн байна.

1.2 Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт нутаг дэвсгэрээр

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь		Өсөлт, бууралтын нэгж
	2018 он	2019 он		2018 он	2019 он	
Улсын хэмжээнд	1280	500	-60.9	3.5	1.6	-1.9
Нийслэлд	1271	487	-61.7	5.0	2.4	-2.6
Орон нутагт	9	13	44.4	0.1	0.1	0.0

1.3 Гэмт хэргийн түвшин /2009-2019 он/




Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 542 гэмт хэрэг бүртгэгдэж, сард 46 хэрэг, хоногт 1 хэрэг үйлдэгдсэн байна.

1.4 Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ням гарагт үйлдэгдсэн хэрэг 80 буюу 57.1, лхагва гарагт 112 буюу 58.9, мягмар гарагт 107 буюу 59.4, бямба гарагт 103 буюу 61.3, баасан гарагт 114 буюу 62.0, даваа гарагт 131 буюу 63.6, пүрэв гарагт 133 буюу 63.7 хувиар тус тус буурчээ.


Хэргийг цагаар нь авч үзвэл 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 258 буюу 63.1, 14-19 цагийн хооронд 310 буюу 55.9, 19-22 цагийн хооронд 128 буюу 64.6, 22-06 цагийн хооронд 84 буюу 71.2 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.





1.5 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад авто замд үйлдэгдсэн хэрэг 1 буюу 2.0 дахин өсч, бусад газарт 3 буюу 8.8, нийтийн тээвэрт 22 буюу 18.0, олон нийтийн газарт 196 буюу 60.5, гэр орон сууцанд 8 буюу 66.7, аж ахуйн нэгжид 52 буюу 67.5, гудамж талбайд 487 буюу 70.1, төрийн бус байгууллагад 3 буюу 75.0, төрийн байгууллагад 10 буюу 90.9 хувиар тус тус буурсан байна.



1.6 Гэмт хэрэг үйлдсэн байдал


Нийт бүртгэгдсэн хэргийн 6 буюу 1.2 хувь нь согтуугаар, 7 буюу 1.4 хувь нь хүүхэд оролцож, 35 буюу 7.0 хувь нь эмэгтэй хүн оролцож, 23 буюу 4.6 хувь нь бүлэглэн үйлдэгдсэн байна.

Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

2.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 103 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 буюу 1.0 хувиар буурсан. Холбогдогчдын 82 буюу 79.6 хувь нь эрэгтэй, 21 буюу 20.4 хувь нь эмэгтэй, 9 буюу 8.7 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс эрэгтэй хүн 7 буюу 7.9 хувиар буурч, эмэгтэй хүн 6 буюу 40.0, хүүхэд 3 буюу 50.0 хувиар тус тус өссөн байна.

2.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал




Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол

3.1 Хохирсон хүн, учирсан хохирол

Гэмт хэргийн улмаас 503 хүн хохирсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 651 буюу 56.4 хувиар буурсан.

Хэргийн улмаас хүнд учирсан 479.9 сая төгрөгийн хохирлын 56.2 сая төгрөг буюу 11.7 хувийг нөхөн төлүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс хохирлын хэмжээ 593.0 сая төгрөг буюу 52.9 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 9.7 сая төгрөг буюу 14.8 хувиар тус тус буурсан байна.



/сая төг-өөр/

---oooOooo---




4.8 МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн хэрэг

1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг


Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлгийн 17.12 дугаар зүйлд заасан “Мал хулгайлах” гэмт хэрэг улсын хэмжээнд 2019 онд 1809 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 713 хэргээр буюу 65.1 хувиар, нийслэлийн хэмжээнд 128 бүртгэгдсэн нь 35 хэргээр буюу 37.6, орон нутгийн хэмжээнд 678 хэргээр буюу 67.6 хувиар тус тус өссөн байна.

1.2 Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт нутаг дэвсгэрээр



	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь		Өсөлт, бууралтын нэгж
	2018 он	2019 он		2018 он	2019 он	
Улсын хэмжээнд	1096	1809	65,1	3,0	5,7	2,7
Нийслэлд	93	128	37,6	0,4	0,6	0,3
Орон нутагт	1003	1681	67,6	9,5	15,0	5,5

1.3 Гэмт хэргийн түвшин /2010–2019 он/



Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 1227, сард 102, хоногт 3 хэрэг үйлдэгдсэн байна.

1.4 Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад бямба гарагт үйлдэгдсэн хэрэг 51 буюу 32.7, баасан гарагт 83 буюу 54.6, мягмар гарагт 100 буюу 59.2, ням гарагт 88 буюу 66.2, лхагва гарагт 114 буюу 71.7, даваа гарагт 132 буюу 77.2, пүрэв гарагт 145 буюу 92.9 хувиар тус тус өсчээ.



Хэргийг цагаар нь авч үзвэл 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 123 буюу 87.2, 14-19 цагийн хооронд 80 буюу 41.9, 19-22 цагийн хооронд 90 буюу 63.8, 22-06 цагийн хооронд 420 буюу 67.4 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.



1.5 Гэмт хэрэг үйлдсэн байдал


Нийт бүртгэгдсэн хэргийн 31 буюу 1.7 хувь нь согтуугаар, 28 буюу 1.5 хувь нь хүүхэд оролцож, 27 буюу 1.5 хувь нь эмэгтэй хүн оролцож, 356 буюу 19.7 хувь нь бүлэглэн, 13 буюу 0.7 хувь нь галт зэвсгээр тус тус үйлдэгдсэн байна.

Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

2.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 1190 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 525 буюу 78.9 хувиар өссөн. Холбогдогчдын 1169 буюу 98.2 хувь нь эрэгтэй, 21 буюу 1.8 хувь нь эмэгтэй, 38 буюу 3.2 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс эрэгтэй хүн 513 буюу 78.2 хувиар, эмэгтэй хүн 12 буюу 2.3 дахин, хүүхэд 22 буюу 2.4 дахин тус тус өссөн байна.

2.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал




Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол


3.1 Хохирсон хүн, учирсан хохирол

Гэмт хэргийн улмаас 1822 хүн хохирсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 715 буюу 64.6 хувиар өссөн байна.

Хэргийн улмаас хүнд учирсан 7543.5 сая төгрөгийн хохирол учирсны 2726.6 сая төгрөг буюу 36.1 хувийг нөхөн төлүүлж, 498.3 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеийнхээс нийт хохирол 3802.8 сая төгрөгөөр буюу 2.0 дахин, нөхөн төлүүлсэн хохирол 1429.0 сая төгрөг буюу 2.1 дахин, битүүмжилсэн хөрөнгө 184.3 сая төгрөг буюу 58.7 хувиар тус тус өссөн байна.



3.2 Алдагдсан малын тоо





4.9 ДЭЭРЭМДЭХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн хэрэг

1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг


Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлгийн 17.2 дугаар зүйл “Дээрэмдэх” гэмт хэрэг улсын хэмжээнд 2019 онд нийт 868 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 629 хэргээр буюу 42.0 хувиар, нийслэлийн хэмжээнд 622 хэргээр буюу 45.7 хувиар, орон нутгийн хэмжээнд 7 хэргээр буюу 5.1 хувиар тус тус буурсан байна.

1.2 Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт нутаг дэвсгэрээр



	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь		Өсөлт, бууралтын нэгж
	2018 он	2019 он		2018 он	2019 он	
Улсын хэмжээнд	1497	868	-42.0	4.1	2.8	-1.3
Нийслэлд	1360	738	-45.7	5.3	3.6	-1.7
Орон нутагт	137	130	-5.1	1.3	1.2	-0.1

1.3 Гэмт хэргийн түвшин /2010-2019 он/




Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 752, сард 63, хоногт 2 хэрэг үйлдэгдсэн байна.



1.4 Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг


Өмнөх оны мөн үетэй харьцуулахад мягмар гарагт үйлдэгдсэн хэрэг 70 буюу 32.3, бямба гарагт 58 буюу 33.9, пүрэв гарагт 89 буюу 38.9, ням гарагт 94 буюу 43.7, баасан гарагт 101 буюу 43.9, даваа гарагт 109 буюу 49.8, лхагва гарагт 108 буюу 50.0 хувиар тус тус буурсан.

Хэргийг цагаар нь авч үзвэл 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 57 буюу 30.2, 14-19 цагийн хооронд 136 буюу 46.1, 19-22 цагийн хооронд 92 буюу 39.7, 22-06 цагийн хооронд 344 буюу 44.0 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.



1.5 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад бусад газарт үйлдэгдсэн хэрэг 1 буюу 1.1 хувиар өсч, гудамж талбайд 447 буюу 43.0, гэр орон сууцанд 84 буюу 48.0, олон нийтийн газарт 64 буюу 48.5, нийтийн тээвэрт 8 буюу 80.0, авто замд 4 буюу 57.1, аж ахуйн нэгжид 21 буюу 58.3, төрийн бус байгууллагад 3 буюу 75.0 хувиар тус тус буурч, төрийн байгууллагад 1 бүртгэгдсэн байна.



1.6 Гэмт хэрэг үйлдсэн байдал

Нийт бүртгэгдсэн хэргийн 87 буюу 10.0 хувь нь согтуугаар, 64 буюу 7.3 хувь нь хүүхэд оролцож, 29 буюу 3.3 хувь нь эмэгтэй хүн оролцож, 144 буюу 16.6 хувь нь бүлэглэн, 1 буюу 0.1 хувь нь гадаадын иргэн үйлдэгдсэн байна.

Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

2.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 529 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18 буюу 3.5 хувиар өссөн. Холбогдогчдын 505 буюу 95.5 хувь нь эрэгтэй, 24 буюу 4.5 хувь нь эмэгтэй, 88 буюу 16.6 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс эрэгтэй хүн 22 буюу 4.6 хувиар өсч, эмэгтэй хүн 4 буюу 14.3, хүүхэд 5 буюу 5.4 хувиар тус тус буурсан байна.

2.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал






Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол

3.1 Хохирсон хүн, учирсан хохирол

Гэмт хэргийн улмаас 875 хүн хохирч, үүнээс 36 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хохирсон хүн 517 буюу 37.1, гэмтсэн хүн 54 буюу 60.0 хувиар тус тус буурсан байна.

Хэргийн улмаас хүнд учирсан 893.9 сая төгрөгийн хохирлын 329.6 сая төгрөг буюу 36.9 хувийг нөхөн төлүүлж, 74.7 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеийнхээс учирсан хохирол 370.0 сая төгрөг буюу 29.3 хувиар буурч, нөхөн төлүүлсэн хохирол 143.0 сая төгрөг буюу 76.7 хувиар өссөн байна.



---oooOooo---



4.10 ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн хэрэг

1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг


Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлгийн 17.3 дугаар зүйл “Залилах” гэмт хэрэг улсын хэмжээнд 2019 онд нийт 4688 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 684 хэргээр буюу 12.7 хувиар, Нийслэлийн хэмжээнд 876 хэргээр буюу 18.5 хувиар буурч, Орон нутгийн хэмжээнд 186 хэргээр буюу 29.8 хувиар өссөн байна.

1.2 Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт нутаг дэвсгэрээр



	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь		Өсөлт, бууралтын нэгж
	2018	2019		2018	2019	
Улсын хэмжээнд	5372	4688	-12.7	14.8	14.9	0.04
Нийслэлд	4735	3859	-18.5	18.5	19.0	0.6
Орон нутагт	623	809	29.9	5.9	7.2	1.3
Бусад	14	20	42.9	21.9	33.9	12.0

1.3 Гэмт хэргийн түвшин /2010-2019 он/




Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 2291, сард 191, хоногт 6 хэрэг үйлдэгдсэн байна.



1.4 Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг


Өмнөх оны мөн үетэй харьцуулахад бямба гарагт үйлдэгдсэн хэрэг 48 буюу 10.1 хувиар өсч, ням гарагт үйлдэгдсэн хэрэг 51 буюу 9.7, мягмар гарагт 100 буюу 11.8, пүрэв 123 буюу 15.0, баасан гарагт 125 буюу 14.8, лхагва гарагт 154 буюу 16.4, даваа гарагт 179 буюу 19.5 хувиар тус тус буурчээ.

Хэргийг цагаар нь авч үзвэл 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 265 буюу 12.5, 14-19 цагийн хооронд 375 буюу 15.5, 19-22 цагийн хооронд 20 буюу 4.1, 22-06 цагийн хооронд 24 буюу 6.9 хувиар тус тус буурсан байна.



1.5 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад бусад газар үйлдэгдсэн хэрэг 82 буюу 7.3, гэр орон сууцанд 44 буюу 4.5 хувиар тус тус өсч, аж ахуйн нэгжид үйлдэгдсэн хэрэг 358 буюу 26.6, олон нийтийн газар 274 буюу 29.6, гудамж талбайд 136 буюу 16.3, төрийн бус байгууллагад 25 буюу 28.1, төрийн байгууллагад 13 буюу 21.0, авто замд 3 буюу 75.0, нийтийн тээвэр 1 буюу 7.7 хувиар тус тус буурсан байна.



1.6 Гэмт хэрэг үйлдсэн байдал


Нийт бүртгэгдсэн хэргийн 23 буюу 0.5 хувь нь согтуугаар, 97 буюу 2.1 хувь нь хүүхэд оролцож, 1005 буюу 21.4 хувь нь эмэгтэй хүн оролцож, 105 буюу 2.2 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.

Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

2.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 1828 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 203 буюу 12.5 хувиар өссөн. Холбогдогчдын 1197 буюу 65.5 хувь нь эрэгтэй, 631 буюу 34.5 хувь нь эмэгтэй, 100 буюу 5.5 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс хүүхэд 57 буюу 2.3 дахин, эрэгтэй хүн 21.9 хувиар тус тус өсч, эмэгтэй хүн 12 буюу 1.9 хувиар буурсан байна.

2.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал






Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол

3.1 Хохирсон хүн, хуулийн этгээд, учирсан хохирол

Гэмт хэргийн улмаас 4691 хүн, 8 хуулийн этгээд хохирсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хохирсон хүн 223 буюу 4.5 хувиар буурч, хуулийн этгээд 4 буюу 2.0 дахин өссөн байна.

Хэргийн улмаас хүн, хуулийн этгээдэд учирсан 89532.2 сая төгрөгийн хохирлын 13232.6 сая төгрөг буюу 14.8 хувийг нөхөн төлүүлж, 735.0 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт хохирол 14368.8 сая төгрөг буюу 13.8, битүүмжилсэн хөрөнгө 23.7 сая төгрөг буюу 3.1 хувиар тус тус буурч, нөхөн төлүүлсэн хохирол 2005.4 сая төгрөг буюу 17.9 хувиар өссөн байна.



/сая төг-өөр/

■ 2018 он ■ 2019 он

---oooOooo---



4.11 МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫГ ХУУЛЬ БУСААР АШИГЛАХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн хэрэг.

1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.


Эрүүлийн хуулийн 20 дугаар бүлэг, 20.7 дугаар зүйл “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар ашиглах” гэмт хэрэг улсын хэмжээнд 2019 онд нийт 257 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 62 хэргээр буюу 31.8 хувиар, нийслэлийн хэмжээнд 201 бүртгэгдсэн нь 51 хэргээр буюу 34.0 хувиар, орон нутгийн хэмжээнд 56 бүртгэгдсэн нь 11 хэргээр буюу 24.4 хувиар тус тус өссөн байна.

1.2 Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт нутаг дэвсгэрээр

Д/д	Нэгж	2018 он	2019 он	Өсөлт, бууралт		Д/д	Нэгж	2018 он	2019 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь					Тоо	Хувь
1	Булган		1	1		Нийслэлд					
2	Дорноговь	1	1	0	0.0	10	Баянгол	38	43	5	13.2
3	Дорнод	2	1	-1	-50.0	11	Баянзүрх	34	41	7	20.6
4	Дархан-Уул	9	2	-7	-77.8	12	Сүхбаатар	24	34	10	41.7
5	Өмнөговь	1	2	1	2.0 дах	13	Сонгинохайрхан	13	15	2	15.4
6	Сэлэнгэ	2	4	2	2.0 дах	14	Хан-Уул	19	29	10	52.6
7	Төв	6	13	7	2.2 дах	15	Чингэлтэй	21	36	15	71.4
8	Орхон	23	32	9	39.1	16	Багануур	1	2	1	2.0 дах
9	Говьсүмбэр	1				17	Багахангай		1	1	

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь		Өсөлт, бууралтын нэгж
	2018 он	2019 он		2018 он	2019 он	
Улсын хэмжээнд	195	257	31.8	0.5	0.8	0.3
Нийслэлд	150	201	34	0.6	1.0	1.0
Орон нутагт	45	56	24.4	0.4	0.5	0.2

1.3 Гэмт хэргийн түвшин /2010-2019 он/




Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 93, сард 8 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

1.4 Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг


Өмнөх оны мөн үетэй харьцуулахад бямба гарагт үйлдэгдсэн хэрэг 2 буюу 15.4, пүрэв гарагт 7 буюу 17.5, даваа гарагт 9 буюу 21.4, мягмар, лхагва гарагт 8 буюу 25.0, баасан гарагт 16 буюу 69.6, ням гарагт 12 буюу 92.3 хувиар тус тус өссөн байна.

Хэргийг цагаар нь авч үзвэл 14-19 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 12 буюу 22.6, 19-22 цагийн хооронд 9 буюу 22.5, 22-06 цагийн хооронд 13 буюу 16.9 хувиар, 06-14 цагийн хооронд 28 буюу 2.1 дахин тус тус өссөн үзүүлэлттэй байна.



1.5 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад гудамж талбай үйлдэгдсэн хэрэг 7 буюу 9.3, гэр, орон сууцанд 15 буюу 25.0, төрийн байгууллагад 1 буюу 33.3, бусад газарт 17 буюу 53.1 хувиар, олон нийтийн газарт 19 буюу 2.1 дахин тус тус өсч, аж ахуйн нэгжид үйлдэгдсэн хэрэг 2 буюу 28.6 хувиар буурч, нийтийн тээвэрт үйлдэгдсэн хэрэг 3, төрийн бус байгууллагад 1, авто замд 1 тус тус бүртгэгдсэн байна.



1.6 Гэмт хэрэг үйлдсэн байдал


Нийт бүртгэгдсэн хэргийн 19 буюу 7.4 хувь нь хүүхэд оролцож, 29 буюу 11.3 хувь нь эмэгтэй хүн оролцож, 64 буюу 24.9 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.

Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

2.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 316 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 63 буюу 24.9 хувиар өссөн. Холбогдогчдын 291 буюу 92.1 хувь нь эрэгтэй, 25 буюу 7.9 хувь нь эмэгтэй, 24 буюу 7.6 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс эрэгтэй хүн 31.1, хүүхэд 20.0 хувиар тус тус өсч, эмэгтэй хүн 19.4 хувиар буурсан байна.

2.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал






4.12 ХҮРЭЭЛЭН БАЙГАА ОРЧНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн хэрэг

1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг

Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлэг “Хүрээлэн байгаа орчны эсрэг” гэмт хэрэг улсын хэмжээнд 2019 онд 489 бүртгэгдсэн нь өмнөх онохоос 123 хэргээр буюу 33.6 хувиар, нийслэлийн хэмжээнд 40 бүртгэгдсэн нь 20 хэргээр буюу 2.0 дахин, орон нутгийн хэмжээнд 449 бүртгэгдсэн нь 103 хэргээр буюу 29.8 хувиар тус тус өссөн байна.

1.2 Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт нутаг дэвсгэрээр




	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь		Өсөлт, бууралтын нэгж
	2018 он	2019 он		2018 он	2019 он	
Улсын хэмжээнд	366	489	33.6	1.0	1.6	0.5
Нийслэлд	20	40	2.0 дах	0.1	0.2	1.0
Орон нутагт	346	449	29.8	3.3	4.0	0.3

1.3 Гэмт хэргийн зүйл анги

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Тухайн гэмт хэрэгт эзлэх хувь
		2018 он	2019 он		
1	24.1 Байгаль орчныг бохирдуулах	5	1	-80.0	0.2
2	24.2 Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох	126	136	7.9	27.8
3	24.3 Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах	15	19	26.7	3.9
4	24.5 Хууль бусаар ан агнах	32	51	59.4	10.4
5	24.6 Хууль бусаар мод бэлтгэх	163	234	43.6	47.9
6	24.7 Ой, хээрийн түймэр тавих	7	12	71.4	2.5
7	24.8 Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх	15	35	2.3 дах	7.2
8	24.9 Байгалийн тэнцэл алдагдуулах	3	1	-66.7	0.2

1.4 Гэмт хэргийн түвшин /2010-2019 он/




Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 311, сард 26, хоногт 1 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.



1.5 Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад мягмар гарагт үйлдэгдсэн хэрэг 20 буюу 31.7, пүрэв гарагт 22 буюу 43.1, баасан гарагт 28 буюу 47.5, лхагва гарагт 26 буюу 50.0, бямба гарагт 20 буюу 51.3, даваа гарагт 24 буюу 54.5 хувиар тус тус өсч, ням гарагт үйлдэгдсэн хэрэг 17 буюу 29.3 хувиар буурсан.

Хэргийг цагаар нь авч үзвэл 06-14 цагийн хооронд 22 буюу 19.8, 22-06 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 16 буюу 25.4, 14-19 цагийн хооронд 58 буюу 41.4, 19-22 цагийн хооронд 27 буюу 51.9 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.



1.6 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад бусад газарт үйлдэгдсэн хэрэг 94 буюу 28.0, гэр орон сууцанд 3 буюу 50.0 хувиар, төрийн байгууллагад 1 буюу 2.0, гудамж талбайд 17 буюу 2.5, авто замд 3 буюу 2.0, олон нийтийн газарт 4 буюу 5.0 дахин тус тус өсч, аж ахуйн нэгж, байгууллагад 2 буюу 25.0 хувиар буурсан байна.

1.7 Гэмт хэрэг үйлдсэн байдал


Нийт бүртгэгдсэн хэргийн 1 буюу 0.2 хувь нь согтуугаар, 3 буюу 0.6 хувь нь хүүхэд оролцож, 23 буюу 4.7 хувь нь эмэгтэй хүн оролцож, 76 буюу 15.5 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.

Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

2.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 359 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 52 буюу 16.9 хувиар өссөн байна. Холбогдогчдын 346 буюу 96.4 хувь нь эрэгтэй, 13 буюу 3.6 хувь нь эмэгтэй, 3 буюу 0.8 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулбал эмэгтэй хүн 4 буюу 23.5 хувиар буурч, эрэгтэй хүн 56 буюу 19.3 хувиар өсч, гэмт хэрэгт холбогдсон хүүхэд өмнөх онтой ижил түвшинд байна.

2.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал






Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол

3.1 Хохирсон хүн, хуулийн этгээд, учирсан хохирол

Гэмт хэргийн улмаас 414 хүн, 13 хуулийн этгээд хохирсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хохирсон хүн 109 буюу 35.7, хуулийн этгээд 5 буюу 62.5 хувиар тус тус өссөн байна.

Хэргийн улмаас хүн, хуулийн этгээдэд учирсан 2576.1 сая төгрөгийн хохирлын 2027.8 сая төгрөг буюу 78.7 хувийг нөхөн төлүүлж, 701.0 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеийнхээс нийт хохирол 18.9 сая төгрөг буюу 0.7 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 965.0 сая төгрөг 90.8 хувиар тус тус өсч, битүүмжилсэн хөрөнгө 475.9 сая төгрөг буюу 40.4 хувиар буурсан байна.



---oooOooo---



4.13 АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, АШИГЛАЛТЫН ЖУРАМ ЗӨРЧИХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн хэрэг

1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг


Энэ төрлийн гэмт хэрэг улсын хэмжээнд 1263 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 48 хэргээр буюу 1.0 хувиар, нийслэлийн хэмжээнд 77 хэргээр буюу 15.1 хувиар тус тус өсч, орон нутгийн хэмжээнд 29 хэргээр буюу 4.1 хувиар буурсан байна.

1.2 Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт нутаг дэвсгэрээр



	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь		Өсөлт, бууралтын нэгж
	2018 он	2019 он		2018 он	2019 он	
Улсын хэмжээнд	1215	1263	4.0	3.4	4.0	0.7
Нийслэлд	511	588	15.1	2.0	2.9	0.9
Орон нутагт	704	675	-4.1	6.7	6.0	-0.7

1.3 Гэмт хэргийн түвшин /2010-2019 он/




Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 1305, сард 109, хоногт 4 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

1.4 Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад даваа гарагт үйлдэгдсэн хэрэг 20 буюу 13.8 хувь өсч, мямгар гарагт 3 буюу 1.6, лхагва гарагт 9 буюу 4.9, пүрэв гарагт 12 буюу 6.2, баасан гарагт 13 буюу 6.6, бямба гарагт 12 буюу 6.9, ням гарагт 19 буюу 10.1 хувиар тус тус буурчээ.

